



# ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

**Хичээлийн нэр:** Тусгай хамгаалалттай газар нутаг ба түүний тогтвортой байдал  
**Protected Areas and its sustainability**

**Хичээлийн индекс:** ENVI.....

**Хичээлийн ангилал:** Магистр, доктор Сонгон судлах хичээл

**Хичээлийн багц цаг:** 3 Бц 6 ECTS  
лекц 2 Бц  
семинар 1 Бц  
лаборатори 0 Бц  
бие даалт 80 Бц

**Судлах улирал:** Бүх улирал

**Нийт хуудасны тоо:** 6

**Цахим хичээл:** <http://online.num.edu.mn/courses/course-v1:NUM+ENVI+2021/about>

## Боловсруулсан:

Бүрэлдэхүүн сургууль	Тэнхим	Багшийн нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХШУИС	Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим	Н.Оюунчимэг, доктор	

## Зөвшөөрсөн:

Бүрэлдэхүүн сургууль/ тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооны нэр	Хэлэлцүүлж зөвшөөрсөн хурлын огноо	Хөтөлбөрийн дэд хорооны даргын нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХБООИ-ийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо		ХБООИТ-ийн хөтөлбөрийн дэд хорооны дарга дэд профессор Ч.Сономдагва	
ХШУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо		ХШУИС-ийн хөтөлбөрийн дэд хорооны дарга профессор Н.Баатарбилэг	

## Баталсан:

Хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны 2020 оны .....-р сарын .....-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

Тамга



### Хичээл заах багш нарын мэдээлэл:

---

Тэнхимийн нэр: Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим  
Багшийн нэр, цол зэрэг: Н.Оюунчимэг, доктор  
Утас: 88000749  
Цахим шуудан: [oyunchimeg@seas.num.edu.mn](mailto:oyunchimeg@seas.num.edu.mn)  
Өрөө: 3-р байрны 313  
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 09:00 – 18:00  
Цахим хуудас: <http://seas.num.edu.mn/>

---

Тэнхимийн нэр: Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим  
Багшийн нэр, цол зэрэг:  
Утас:  
Цахим шуудан:  
Өрөө:  
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 09:00 – 18:00  
Цахим хуудас: <http://seas.num.edu.mn/>

---



## ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

Өмнө үзсэн байх хичээлийн нэр, индекс:

1. Хүрээлэн буй орчин судлал ENVI200
2. Байгаль орчны хамгаалал ENPT201

Зэрэг үзэхэд тохиромжтой хичээлийн нэр, индекс:

1. Тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн бодлого ENVI312

## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Энэ хичээл нь оюутнуудад Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх үндсэн ойлголт, хамгааллын менежмент болон менежментийн төлөвлөгөө боловсруулах, мөн менежментийн үр ашигт байдлыг үнэлэх арга, аргачлалын талаар мэдлэг олгох гол зорилготой. Түүнчлэн оюутнуудад дараах мэдлэгийг олгоно. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн зорилгод ТХГН-ийн гүйцэтгэх үүрэг
2. ТХГН-ийн ангилал болон тэдгээрийн менежментийн зорилго
3. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах үйл явц
4. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлыг үнэлэх үйл явц
5. ТХГН-т тулгамдаж буй асуудлууд

Түүнчлэн Монгол орны ТХГН-ийн талаар бүрэн цогц мэдээлэл өгч, шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлнэ.

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Энэ хичээлээр ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлыг үнэлгээний МЕТТ аргачлал болон хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын (MIRADI-д суурилсан) талаар судална. Уг хичээл нь байгалийн ухааны салбарын магистр, докторын хөтөлбөрийн байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны менежменттэй илүү уялдана. Мөн тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, засаглал, тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн холбогдож буй талаар ойлголт өгнө. Хичээлийн хүрээнд мэдээ цуглуулах, түүндээ анализ хийх, бие даан болон багаар ажиллахын зэрэгцээ хээрийн ажиглалт, илтгэл тавих, тайлан бичнэ.

[This course serves as an introduction to METT of Protected area's management effectiveness and MIRADI based approach for developing management plan for PAs. The course is more closely related to environmental and environmental management \(and a limited exposure to multidisciplinary environmental studies\) in master's and doctoral programs in natural science. It also provides a basic understanding of PA management and governance, and how protected areas are linked to sustainable development goals. During the course, students will collect and analyze data, work independently and in teams, and make field observations, presentations, and reports.](#)

## ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ

Эзэмших мэдлэг:

- ~ ТХГН-ийн сүлжээ болон ТХГН-ийн менежментийн тухай ойлголт
- ~ ТХГН-ийн засаглал, түүний гол оролцогчид
- ~ ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал
- ~ ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлыг үнэлэх аргачлал
- ~ Оролцогч талуудын уулзалт зохион байгуулах, мэдээллийн анализ, дүн шинжилгээ

Эзэмших чадвар, дадал:

- ~ ТХГН нь байгаль хамгаалал болон тогтвортой хөгжлийн зорилгод ямар үүрэгтэй болохыг дүгнэх
- ~ ТХГН-т тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх
- ~ МЕТТ-г ашиглан ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлыг үнэлэх
- ~ MIRADI программ ашиглах
- ~ Хээрийн судалгаа, ажиглалт хийх
- ~ Тайлан бичих, багийн хэлэлцүүлэгт оролцох, илтгэл хэлэлцүүлэх



## ЗААХ АРГА БАРИЛ

Хичээлийг шавь төвт сургалтын арга барилд тулгуурлан явуулах ба лекц, харилцан яриа, семинар, бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээ цуглуулж анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр явагдана.

## ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР:

Хичээлийн явцад дараах 2 сэдвээр бие даалт өгч, явцын илтгэл тавиулна. Үүнд:

1. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулалт
2. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ

## ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (идэвх, явц, шалгалт)

Дүгнэх ажлууд	Оноо	Тайлбар
Ирц	30	Хичээлд хамрагдсан байдал
Идэвх (Бие даалт)	30	Идэвхийг бие даалтын гүйцэтгэлээр үнэлнэ.
Улирлын шалгалт	40	Хичээлийг ойлгосон байдал
Нийт	100	

## ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Хэлбэр	Цаг
1	ТХГН-ийн сүлжээ – үндсэн ойлголт	ТХГН-ийн сүлжээний түүхэн хөгжил, ТХГН-ийн зорилго, ач холбогдол, үүрэг	Лекц	4
2	ТХГН-ийн ангилал ба Биологийн олон янз байдлын (БОЯБ) тухай олон улсын конвенц	ТХГН-ийн ОУ-ын ангилал ба тодорхойлолт, Биологийн олон янз байдлын (БОЯБ) тухай олон улсын конвенц	Лекц	4
3	Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг	Хил дамнасан тусгай хамгаалалттай газар болон Олон улсын хамгаалалттай газрын тухай ойлголт өгнө.	Лекц Семинар	4
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт – үндсэн ойлголт	Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт, түүний ач холбогдол, ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний онцлог, аргачлал	Лекц Семинар	4
5	Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт – боловсруулах аргачлал	ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд суралцах. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах MIRADI программ ашиглах.	Лекц Семинар	4
6	ТХГН-ийн менежментийн үр ашигт байдал	ТХГН-ийн менежментийн үр ашигт байдал болон түүний үнэлгээний аргуудын тухай, МЕТТ аргачлалын тухай ойлголт өгнө.	Лекц Семинар	4
7	МЕТТ-н хэрэглэн ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлыг үнэлэх нь	ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээнд МЕТТ-ийг ашиглахад суралцана.	Лекц Семинар	4
8	МУ-ын ТХГН-ийн сүлбээ	МУ-ын ТХГН-ийн сүлжээний үүсэл хөгжил, онцлог, ач холбогдол, ангиллын талаар ойлголт авна.	Лекц Видео	4
9	ТХГН-ийн байгалийн бүс, бүслүүр дэх төлөөлөл	МУ-ын ТХГН-ийн байгалийн бүс, бүслүүр дэх төлөөллийн үнэлгээний үр дүнтэй танилцана.	Лекц Семинар	4
10	ТХГН-ийн засаглал	ТХГН-ийн засаглал гэж юу болох, засаглалын төрлүүд, засаглалд оролцогч талууд	Лекц Семинар	4
11	ТХГН-ийн санхүүжилт	ТХГН-ийн санхүүжилтийн эх үүсвэрүүд, эрхзүйн орчин болон тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх боломж	Лекц Семинар	4
12	ТХГН ба Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ) харилцан уялдаа	ТХГН-ийн хөгжил, хамгааллын менежментийн үр дүн тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хэрхэн холбогдож байгаатай танилцах	Лекц Семинар	4
13	ТХГН-т тулгамдаж буй асуудал	Дэлхийн болон МУ-ын ТХГН-уудад тулгамдаж буй нийтлэг болон онцлог асуудлууд	Лекц Семинар	4
14	Газар дээрх ажиглалт судалгаа – 1	Богд Хаан уулын ДЦГ ба Хамгаалалтын захиргаанд зочилж үйл ажиллагаатай танилцаж, менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах	Семинар	4
15	Газар дээрх ажиглалт судалгаа – 2	Богд Хаан уулын ДЦГ-ын менежментийн үр ашигт байдлыг МЕТТ ашиглан үнэлэх	Семинар	4
16	Хээрийн ажлуудын нэгдсэн үр дүн	МТ болон үр ашигт байдлын үнэлгээний тайлангуудыг бичих, илтгэл тавих	Семинар	4
	Нийт			64

Бүгд: 64 цаг лекц 32 цаг семинар 32 цаг



## ХИЧЭЭЛЭЭР АШИГЛАХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

### Заавал:

1. МУ-ын УИХ (1994). МУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
2. МУ-ын УИХ (2016). МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030
3. Мягмарсүрэн Д., Намхай А., 2012. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Мөнхийн үсэг. УБ. 409 х.
4. Оюунгэрэл Б (2004). Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг, УБ.
5. Оунчимег, N., Altansukh, O and *et al* (2019). Evaluating the management effectiveness of protected areas in Mongolia using the management effectiveness tracking tool, *Environmental Management*, Springer, volume 63, No 2, 249-259. ). <https://doi.org/10.1007/s00267-018-1124-4>
6. UNEP-WCMC, IUCN, and NGS (2018). Protected Planet Report 2018. UNEP-WCMC, IUCN, and NGS: Cambridge UK; Gland, Switzerland; and Washington, D.C., USA.
7. G. L. Worboys, M. Lockwood, A. Kothari, S. Feary and I. Pulsford (eds) (2015). Protected Area Governance and Management, ANU Press, Canberra.
8. Ervin, J., N. Sekhran, A. Dinu. S. Gidda, M. Vergeichik, and J. MEE (2010). Protected Areas for the 21st Century: Lessons from UNDP/Gef's Portfolio. New York: United Nations Development Programme and Montreal: Convention on Biological Diversity.
9. Sachs, J., Schmidt-Traub, G., Kroll, C., Lafortune, G., Fuller, G (2019). Sustainable Development Report 2019. New York: Bertelsmann Stiftung and Sustainable Development Solutions Network (SDSN).
10. Stolton, S. and N. Dudley (2016). METT Handbook: A guide to using the Management Effectiveness Tracking Tool (METT), WWF-UK, Woking

### Нэмэлт:

11. Geldmann, J., Coad, L., Barnes, M., Craigie, I.D., Hockings, M., Knights, K., Leverington, F., Cuadros, I.C., Zamora, C., Woodley, S. and Burgess, N.D., 2015. Changes in protected area management effectiveness over time: a global analysis. *Biological Conservation*, 191, pp.692-699.
12. Barnes M., Craigie I.D., Harrison L., et al. 2016. Wildlife population trends in PAs predicted by national socio-economic metrics and body size. *Nature Communications* 7, 12747, 1-9.
13. Geldmann, J., Barnes, M., Coad, L., Craigie, I.D., Hockings, M., Burgess, N.D., 2013. Effectiveness of terrestrial protected areas in reducing habitat loss and population declines. *Biol. Conserv.* 161, 230–238. DOI:10.1016/j.biocon.2013.02.018.
14. Sellars, R.W., 2009. Preserving nature in the national parks: a history: with a new preface and epilogue. Yale University Press.